



БАЙГУУЛЛАГЫН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгууллагын нэр: Боловсролын мэдээллийн технологийн төв

ТӨЛӨВЛӨГӨӨ БАТАЛСАН:

БОЛОВСРОЛЫН САЙД

(албан тушаал)

тэмдэг

/П.НАРАНБАЯР/

(гарын үсэг)

(огноо)

ATA12937 9116621 702407582

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

(албан тушаал)

тэмдэг

/Д.БАТ-ЭРДЭНЭ/

(гарын үсэг)

(огноо)

**"БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ" УТУГ-ЫН
2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОВЬЁГ**

№	Үндсэн чиг үүрэг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хуудасны дугаар
1.	Боловсролын салбарын мэдээллийн систем, мэдээллийн сан болон программ хангамжийн хөгжүүлэлтийн талаар	1	18	3-11
2.	Сургалтын цахим контент удирдлагын систем болон программ хангамжийн хөгжлийн асуудлыг цогцоор нь хэрэгжүүлэх	1	2	11-12
3.	Боловсролын цахим үйлчилгээг өргөжүүлэх талаар	1	4	12-15
4.	Боловсролын салбарын мэдээллийн системийн хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, тогтвортой ажиллагааг хангах	1	13	15-19
5.	Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлага	1	13	20-23
Нийт		5	50	

**БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ" УТУГ-ЫН
2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа	Хариуцах нэгж
Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ							
1.	<p>Боловсролын салбарын мэдээллийн систем, мэдээллийн сан болон программ хангамжийн хөгжлийн асуудлыг цогцоор нь хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого / үе шат (2021-2030) зорилт 2.1.2, 2.1.4, 2.1.5 - Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дугаартай "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" тогтоолын 1-р хавсралт "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" 2.2.1.13, 2.2.4.1 - "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" 2.2.4.1, 2.2.4.2, 2.2.4.3, 2.2.4.5 - Боловсролын ерөнхий хууль 8.2, 12.12, 43.1 						
1.1	Боловсролын салбарын төсвийн шинэчлэлтэй холбоотой төлөвлөлтийн үйл ажиллагааны судалгаа хийх, системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, тогтвортой байдлыг хангах	Улсын төсөв	"Төсвийн төсөл 2027" дэд системийн сайжруулалт, өөрчлөлт хийсэн индекс, маягт, тайлангийн тоо	ЕБС, СӨББ-ын 2026 оны төсвийн төслийг дэд системээр нэгтгэсэн.	Эхний хагас жилд: Төсвийн төсөл дэд системийн нэмэлт, өөрчлөлт, сайжруулалтын ажлыг эхлүүлнэ. Жилийн эцэст: Төсвийн төсөл дэд системд шаардлагатай сайжруулалтын ажлыг гүйцэтгэж, салбарын 2027 оны төсвийн төслийг нэгтгэх системийн тогтвортой байдлыг хангасан байна.	II улирал, III улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
1.2	Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын мэдээллийн системийг хөгжүүлэх, үе шаттайгаар нэвтрүүлэх	Улсын төсөв	-Шинээр хөгжүүлсэн модулийн тоо -Сайжруулалт хийгдсэн, хөгжүүлсэн ажлын тоо	Бодит орчинд хөгжүүлэлт хийсэн 8 модуль : - Байгууллага - Тусгай зөвшөөрөл - Хөтөлбөр төлөвлөгөө - Хичээл	Эхний хагас жилд: Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын мэдээллийн системийн сайжруулах шаардлагатай ажлуудыг гүйцэтгэн, өдөр тутмын үйл ажиллагааг тогтвортой байдлыг хангаж, И-монгол системээс суралцагчийн лавлагаа гардаг болсон байна. Жилийн эцэст:	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс

			-Статистик тайлангийн тоо	- Суралцагч - Ирц - Хүний нөөц-ажлын байр - Эрхийн тохиргоо	МБТБ-ын албан ёсны болон захиргааны маягтын дагуу тайлангийн хөгжүүлэлтийг эхлүүлсэн байна.		
1.3	ЕБС, СӨБ байгууллага дээр ашиглагдаж буй систем болон бусад салбарын мэдээллийн системтэй мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх.	Улсын төсөв	-Шинээр нэвтрүүлсэн болон сайжруулсан мэдээлэл солилцооны сервисийн тоо	- Боловсрол, сургалтын байгууллагад ашиглагдаж буй сургуулийн удирдлагын систем, сургалтын удирдлагын системтэй мэдээлэл солилцох 123 сервисийг хөгжүүлсэн.	Эхний хагас жилд: Боловсролын сургалтын байгууллагад (ЕБС) ашиглагдаж буй сургуулийн удирдлагын системийн менежерийн дэвшилт, төгсөлтийн хэсгийн мэдээлэл солилцоог хөгжүүлж, ЛМС руу бүрэн шилжүүлсэн байна. Нэгдсэн стандартын дагуу dev 2.0 системд гарсан сервисийг сайжруулан шинэчлэн гаргаж хэвийн ажиллагааг хангасан байна. Жилийн эцэст: Боловсролын сургалтын байгууллагад (СӨБ, ЕБС) ашиглагдаж буй сургуулийн удирдлагын систем, сургалтын удирдлагын болон салбарын бусад мэдээллийн системтэй мэдээлэл солилцох шаардлагатай (журамд заасны дагуу) нэмэлт сервисүүдийг батлагдсан төлөвлөгөөний дагуу сайжруулалт хийж, шинээр хөгжүүлэн сургалт, мэдээлэл өгсөн байна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
1.4	Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотой ном тайланг хөгжүүлэх	Улсын төсөв	-Шинээр хөгжүүлсэн болон сайжруулалт хийсэн ном тайлангийн тоо	Ерөнхий боловсролын сургуулиудад 6 төрлийн сургалтын хөтөлбөр хэрэгжиж байна.	Жилийн эцэст: Ерөнхий боловсролын сургуулийн бага ангид хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд хөтөлбөрийн мэдээлэл шинэчлэгдсэнтэй холбогдуулан мэдээлэл солилцогч байгууллагуудад мэдээлэл хүргүүлж, гаргасан сервис болон сургалтын хөтөлбөрийн шинэчлэл хийсэнтэй холбогдуулан системийн хэвийн үйл ажиллагааг хангаж, тайлангууд гарсан байна.	IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс

1.5	Мэргэшлийн зэрэг олгохтой холбоотой системийн хөгжүүлэлт сайжруулалт хийх	Улсын төсөв	-Сайжруулалт хийгдсэн функцуудын тоо	- Боловсролын сайдын 2024 оны А/95 тушаалаар "Мэргэшлийн зэрэг олгох тухай" журам шинэчлэн батлагдсан. Энэ журмын дагуу системд өмнө нь авч байсан мэргэшлийн зэрэг нь 5 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна гэдэг тохируулга системд хийж хүсэлтүүдийг хүлээн авч шийдвэрлэсэн.	Эхний хагас жилд: Хүчингүй болсон журам буюу Боловсролын сайдын 2013 оны А/305 тушаалын 6.3-ын дагуу зөвлөх зэрэг авсан багш нарын мэргэшлийн зэрэг нь 10 жилийн хугацаанд хүчинтэй гэж заасантай зөрчилдөх болон гомдол гаргасан ажилтны мэдээллийг дахин магадлах шаардлага үүсэж байгаатай холбогдуулан төлөвийн өөрчлөлт хийх, шийдвэрлэх шаардлага үүсээд байгаа асуудлаар БЕГ-тай хамтарсан уулзалт хийж шийдвэрлэх шаардлагатай ажлуудын тухай танилцуулж, БЕГ-аас ажлын даалгавар авч түүний дагуу судалгаа, шинжилгээ хийнэ. Жилийн эцэст: Мэргэшлийн зэргийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн мэдээллийг бүтэн жилээр нэгтгэн дээд шатны байгууллагад хүргүүлнэ.	II улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
1.6	Боловсролын салбарын мэдээллийн системийн технологийн сайжруулалт хийх болон сервис үйлчилгээг чанаржуулах	Улсын төсөв	-Сайжруулсан болон шинээр хийгдсэн ажлын тоо -Стандарт хангасан сервисийн тоо	Суурь системийн технологи хуучирсан ба шинэчлэл орох боломжгүй болсон.	Эхний хагас жилд: Дата баазын нэршил болон гаргаж буй сервисүүдэд баримтлах стандарт шаардлага боловсруулж, батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэн, мэдээлэл солилцогч байгууллагуудад стандарт шаардлага болон цаашид баримтлах шаардлагатай мэдээлэл хүргүүлсэн байна. Жилийн эцэст: Суурь системийг хөрвүүлэн EMIS-д хийгдэх ажлын бодлого шийдэл тодорхойлж, төлөвлөгөөний дагуу хөгжүүлэлт эхэлсэн байна. ЕБС, СӨБ-ын статистик тайланд оролцох шаардлагатай ба шаардлагагүй байгууллагуудыг нэмэх, хасах үйл ажиллагааг интерфэйсжүүлэх судалгаа, шинжилгээ, хөгжүүлэлт хийж, нэвтрүүлнэ.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс

1.7	Боловсролын салбарын мэдээллийн системийн хэрэглэгчийн эрхийн зохицуулалт хийх болон мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах	Улсын төсөв	-Сайжруулалт хийсэн хэрэглэгчийн эрхийн тоо, -Сайжруулалт хийсэн модулийн тоо	Боловсролын сайдын 2025 оны А/465 тоот тушаал, тушаалын хэрэгжилтийг хангахтай холбоотой Боловсролын яамны ТНБД-ын 2025 оны албан бичиг батлагдаж, НЕМИС - д өөрчлөлт хийгдсэн. ESIS -д хэсэгчилсэн буюу суралцагч баталгаажуулах үйл ажиллагааг шийдвэрлэх өөрчлөлт хийгдсэн.	Эхний хагас жилд: Батлагдсан эрхийн тохиргооны дагуу боломжтой сайжруулалтыг хийж тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагааг хангана. Жилийн эцэст: Боловсролын яамны харьяа байгууллага болон БСМС хэрэглэгч бүрийн хэрэгцээ шаардлагыг батлагдсан бүтэц болон нууцын баталгаанд үндэслэж харуулах модуль болон хэрэгцээ шаардлагад нь нийцүүлэн олгох зэрэг зохицуулалт хийж тушаалын хэрэгжилтийг хангасан байна.	II улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
1.8	Ерөнхий боловсрол ба Сургуулийн өмнөх боловсролын шинэ байгууллага бүртгэх үйл ажиллагааг интерфэйсжүүлэх судалгаа, шинжилгээ, хөгжүүлэлт хийх	Улсын төсөв	Сайжруулалт болон шинээр хийсэн модулийн тоо	ЕБС-ийн шинэ байгууллага бүртгэх үйл ажиллагааны судалгаа хийж хөгжүүлэлт хийсэн. СӨБ-ын хувьд одоогоор хийгдсэн систем байхгүй.	Эхний хагас жилд: ЕБС-ийн шинэ байгууллага бүртгэх үйл ажиллагааны сайжруулалт хийж нэвтрүүлсэн байна. Жилийн эцэст: СӨБ-ын шинэ байгууллага нэмэх үйл ажиллагааг шинээр судалгаа, шинжилгээ, дэлгэцийн зураглал, судалгааны материал бэлтгэж хөгжүүлэлт хийж, нэвтрүүлсэн байна	II улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
1.9	Хоол үйлдвэрлэлийн нэгтгэл системийн хөгжүүлэлт	Улсын төсөв	Сайжруулалт, хөгжүүлэлт хийсэн модулийн тоо	Засгийн газрын 73-р тогтоол, Боловсролын сайдын 2024 оны А/84, Боловсролын сайдын 2024 оны 1а/492 дугаартай тушаалын хэрэгжилтийг хангаж ирцэд үндэслэн санхүүжилт олгох	Эхний хагас жилд: БЕГ -аас ажлын даалгавар хүлээн авч, судалгаа шинжилгээ хийж "Сүү" хөтөлбөрийн биелэлтийг нэгтгэн харуулах, тайлан харах боломжтой системд хийнэ. Системийн төлөвлөлтийн дагуу нэмэлт сайжруулалт, засвар хийж, тогтвортой ажиллагааг хангана. Жилийн эцэст: Систем хөгжүүлэгчдээс хоолны хуваарь, шим тэжээлийн мэдээлэл, сүү хөтөлбөрийн хэрэгжилт	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс

				системийн нийслэлд хэрэгжүүлсэн.	зэрэг мэдээллийг хүлээн авах сервис шинээр хөгжүүлнэ.		
1.10	Шинэчлэн батлагдсан журмын дагуу суралцагч бүртгэлийн модуль системд хөгжүүлэлт хийх, суралцагч дүйцүүлэх, баталгаажуулах, шилжилт хөдөлгөөний шийдвэрлэлт	Улсын төсөв	Батлагдсан аргачлалын тоо, Сайжруулалт хөгжүүлэлт хийсэн модулийн тоо	Боловсролын сайдын А/187 Суралцагчийн дүйцүүлэх журмын дагуу ажлын даалгавар гаргасан.	Эхний хагас жилд: Батлагдсан журам, ажлын даалгаврын дагуу үндсэн мастер дата болох суралцагч, багш ажилтны бүртгэлийн аргачлалыг Боловсролын яам, БЕГ, НБГ, БГ гэх бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулахад оролцож, ЕБС-ийн менежер болон суралцагчтай холбоотой баталгаажуулалт, дүйцүүлэх үйл ажиллагааны процессыг тодорхойлж, ажлын хэсгийн гаргасан шийдвэрийн дагуу судалгаа, системийн хөгжүүлэлтийн төлөвлөгөө, "Суралцагч, багш ажилтны бүртгэлийн аргачлал" баталгаажуулж, мэдээлэл солилцох үйл ажиллагааг эхлүүлсэн байна. Жилийн эцэст: Бүртгэлийн аргачлалын дагуу шаардлагатай хөгжүүлэлтийг хийж, ЕБС-ийг суралцагч бүртгэх үйл ажиллагааг ESIS-д хийхгүй болгосон байна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
1.11	Дээд боловсролын сургалтын байгууллага дээр ашиглагдаж буй систем болон бусад салбарын мэдээллийн системтэй мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх	Улсын төсөв	Шинээр нэвтрүүлсэн мэдээлэл солилцооны сервисийн тоо,	Дээд боловсролын систем дээр 23 сервис шинээр хөгжүүлсэн бөгөөд туршаагүй байна.	Эхний хагас жилд: Дээд боловсролын сургалтын байгууллагад ашиглагдаж буй сургуулийн удирдлагын системийн анхан шатны мастер дата мэдээлэл солилцоог төлөвлөгөөний дагуу хөгжүүлж, ЛМС-тэй мэдээлэл солилцон туршиж эхэлсэн байна. Нэгдсэн стандартын дагуу dev 2.0 системд гарсан сервисийг сайжруулан шинэчлэн гаргаж хэвийн ажиллагааг хангасан байна. Жилийн эцэст: Дээд боловсролын сургалтын байгууллагад ашиглагдаж буй сургуулийн удирдлагын системийн шаардлагатай бүх мэдээллийн солилцоог төлөвлөгөөний дагуу хөгжүүлж, ЛМС-тэй	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс

					мэдээлэл солилцон бодит орчинд нэвтрүүлсэн байна.		
1.12	Дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ, чансаа, ангилал тогтооход шаардлагатай үзүүлэлт, индикаторыг системээр гаргах, хөгжүүлэлт хийх	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр	-Сайжруулалт болон шинээр хөгжүүлсэн модулийн тоо, - Судалгааны бичиг баримтын тоо	Одоогоор хийгдсэн систем байхгүй	Эхний хагас жилд: Дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ, чансаа, ангилал тогтооход шаардлагатай үзүүлэлт, индикаторыг системээр гаргах бодлого шийдлийг боловсруулан Боловсролын яамны саналыг тусган баталгаажуулж, эхний 1-3 тайланг боловсруулан хөгжүүлсэн байна. Жилийн эцэст: Төсөв, ажлын даалгавар боловсруулан тухайн ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтаар шалгаруулж, тус ажлыг гүйцэтгүүлж системийг нэвтрүүлэн, хэвийн ажиллагаанд оруулсан байна. Дээд боловсролын сургалтын байгууллага, харьяа байгууллагуудад байгаа дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг тогтооход ашиглагдах үзүүлэлт, өгөгдлийн санг нэгтгэсэн цахим мэдээллийн санг үүсгэнэ.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
1.13	Боловсролын салбарын нэгдсэн сүлжээний хэвийн ажиллагааг хангах	Улсын төсөв	Шинээр холбосон сургууль, хичээлийн байрны тоо Сүлжээний холболтын тогтвортой ажиллагааг хангасан сургууль, хичээлийн байрны тоо Нийт зурвасын өргөн (Gbps) Дотоод сүлжээ байгуулсан сургуулийн тоо	Боловсролын нэгдсэн сүлжээнд 21 аймаг, 9 дүүрэг, 330 сумын төрийн өмчит сургуулиуд холбогдсон.	Эхний хагас жилд: Боловсролын нэгдсэн сүлжээнд шинээр ерөнхий боловсролын сургууль, хичээлийн байр холбох, сүлжээний тогтвортой байдлыг ханган ажилласан байна. Жилийн эцэст: Боловсролын нэгдсэн сүлжээнд шинээр ерөнхий боловсролын сургууль, хичээлийн байр холбох, сүлжээний тогтвортой байдлыг ханган ажилласан талаар тайлан мэдээг бүтэн жилийн байдлаар гарган дээд шатны байгууллагад танилцуулна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	"Эрдэмнэт" сүлжээний хэлтэс

1.14	"edu.mn домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам"-ын хэрэгжилтийг хангах, домэйн нэрийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх	Улсын төсөв	.edu.mn домэйн нэрийн DNS дэд бүтцийн өнөөгийн байдалд техникийн үнэлгээ хийж, DNS серверийн архитектур, нэрийн серверүүдийн байршил, нөөцлөлт, түлхүүрийн удирдлага (KSK, ZSK), автоматжуулалтын боломж, системийн найдвартай ажиллагаа болон аюулгүй байдлын түвшнийг тодорхойлсон байна. Үнэлгээний дүнд DNSSEC стандарт нэвтрүүлэх техникийн шаардлага, хэрэгжүүлэх үе шат, шаардлагатай нөөцийн тооцоог боловсруулсан байна.хх	Домэйн нэрийн бүртгэл, техникийн удирдлагыг журмын дагуу хэрэгжүүлж байгаа боловч домэйн нэрийн ашиглалтын нэгдсэн судалгаа хийгдээгүй, DNSSEC аюулгүй байдлын стандарт бүрэн нэвтрээгүй байна.	Эхний хагас жилд: .edu.mn домэйн нэрийн бүртгэл, ашиглалт, зөрчил, эрсдэлийн иж бүрэн судалгаа хийж, DNSSEC нэвтрүүлэх техникийн болон зохион байгуулалтын бэлэн байдлын үнэлгээ, хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулсан байна. Жилийн эцэст: Судалгаанд үндэслэн домэйн нэрийн нэгдсэн удирдлагын тогтолцоог сайжруулж, DNSSEC аюулгүй байдлын стандартын нэвтрүүлэлтийг үе шаттайгаар эхлүүлсэн байна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	"Эрдэмнэт" сүлжээний хэлтэс
1.15	Эрдэм шинжилгээ, сургалтын TEIN сүлжээний олон улсын гарцын зурвасын өргөнийг нэмэгдүүлж, хэрэглэгчдийн хүрээг тэлэх	Улсын төсөв	Гарцын хурд(Gbps) Шинээр холбогдсон байгууллагын тоо	TEIN сүлжээний олон улсын гарцын хурд 150 Mbps байна. TEIN сүлжээнд МУИС, ШУТИС, АШУУИС, МОНГОЛ-ЯПОНЫ	Эхний хагас жилд: TEIN гарцын хурдыг 1 Gbps болгон нэмэгдүүлнэ. Жилийн эцэст: ХААИС болон ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийг сүлжээнд холбоно. Мөн "Чингис хаан" музей болон Үндэсний төв номын санг төсөв, техникийн бэлэн байдлын нөхцөл	I улирал, II улирал, III улирал, IV улирал	"Эрдэмнэт" сүлжээний хэлтэс

				эмнэлэг, МУБИС холбогдсон байна	боломжид нийцүүлэн сонголт хийж шинээр холбоно.		
1.16	Сургуулиудын интернэт үйлчилгээний гэрээний биелэлтийг хянах (SLA Monitoring) системийг нэвтрүүлж, үр дүнг тооцох	Улсын төсөв	Хяналтад хамрагдсан сургуулийн хувь Гэрээний үүрэг зөрчигдсөн тухай автомат мэдэгдлийн тоо Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын гүйцэтгэлийн тайлангийн чанар	Сургуулиудын интернэт хэрэглээний чанарыг (Latency, Speed) хэмжих нэгдсэн системгүй тул гэрээний биелэлтийг зөвхөн хэрэглэгчийн санал гомдолд тулгуурлан дүгнэж байна.	Эхний хагас жилд: Giga төслийн хүрээнд Ping, Latency, Speed (Download/Upload) үзүүлэлтийг хэмжих системийг суурилуулж, өгөгдөл цуглуулах процессыг автоматжуулсан байна. Жилийн эцэст: Цуглуулсан өгөгдлийг гэрээний нөхцөлтэй (SLA) тулган, үйлчилгээний чанарын үнэлгээг системээс автоматаар гаргадаг болсон байна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	"Эрдэмнэт" сүлжээний хэлтэс
1.17	Боловсролын салбарын мэдээллийн систем, сүлжээ, серверийн өрөө, төвийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах	Улсын төсөв	Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийсэн системийн тоо Эрсдэлийн үнэлгээний зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо Нөөцлөлтөд хамрагдсан мэдээллийн систем, мэдээллийн сангийн хувь Мэдээллийн аюулгүй байдлын сургалтад хамрагдсан ажилтны тоо Серверийн өрөө, дэд бүтцийн аюулгүй байдлын	Мэдээллийн систем, мэдээллийн сан, серверийн орчны мэдээллийн аюулгүй байдлын үнэлгээ, нөөцлөлт бүрэн бус хэсэгчлэн хэрэгжсэн.	Эхний хагас жилд: Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилтнуудад сургалт, заавар, зөвлөмж хүргүүлж, боловсролын мэдээллийн систем, мэдээллийн санг нөөцөлсөн байна. Жилийн эцэст: Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн мэдээллийг бүтэн жилийн байдлаар нэгтгэн дээд шатны байгууллагад танилцуулна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	"Эрдэмнэт" сүлжээний хэлтэс

			шаардлага хангасан байдал				
1.18	Боловсролын мэдээллийн систем, дэд бүтцийн хэвийн үйл ажиллагаа, тогтвортой байдлыг хангах	Улсын төсөв	Системийн тасралтгүй ажиллагааны хувь Төлөвлөгөөт бус зогсолтын тоо Өгөгдлийн нөөцлөлт (Backup)-д хамрагдсан системийн хувь Гэнэтийн саатлыг шийдвэрлэсэн хугацаа (SLA)	Салбарын сервер болон мэдээллийн системийн дэд бүтцийг виртуал орчинд төвлөрүүлэн ашиглаж байгаа боловч өгөгдлийн хэмжээ болон хэрэглэгчийн тооны өсөлтөөс шалтгаалан тооцоолон бодох болон хадгалах нөөцийн (CPU, RAM, Storage) ашиглалт дүүргэлт өндөр түвшинд хүрч, системийн тогтвортой ажиллагаанд эрсдэл үүсээд байна.	Эхний хагас жилд: Боловсролын салбарын бүх системийн тогтвортой байдлыг хангах техникийн болон программ хангамжийн шинэчлэлийг хийж, тогтвортой байдлыг хангасан байна. Data Warehouse (мэдээллийн агуулах) санг бүрэн шилжүүлж, өгөгдлийн боловсруулалт, тайлан гаргалтын хурдыг нэмэгдүүлсэн байна. Жилийн эцэст: Боловсролын мэдээллийн систем, дэд бүтцийн хэвийн ажиллагаа, тогтвортой байдлыг хангасан байна. Transactional болон Infrastructure сангуудыг шилжүүлэн, хэвийн ажиллагааг хангасан байна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	"Эрдэмнэт" сүлжээний хэлтэс
2.	<p>Сургалтын цахим контент удирдлагын систем болон программ хангамжийн хөгжлийн асуудлыг цогцоор нь хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хэвсрэлт "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого / үе шат (2021-2030) зорилт 2.1.2, 2.1.4, 2.1.5 дахь заалтууд - Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дугаартай "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" тогтоолын 1-р хэвсрэлт "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" 2.2.1.13, 2.2.4.1 - "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" 2.2.4.1, 2.2.4.2, 2.2.4.3, 2.2.4.5 заалтууд, - Боловсролын ерөнхий хууль 8.2, 12.12, 43.1 дэх заалтууд 						
2.1	Цахим сургалтын платформ Medle.mn - ийн багш, суралцагчийн дэд системийн хэвийн, тогтвортой байдлыг хангах	Улсын төсөв	Байршуулсан шинэ контентын тоо	Мэдлэ 2.0 вэб хувилбар нь туршилтын байдлаар ашиглагдаж байна.	Эхний хагас жилд: Мэдлэ цахим контентын системд "Сайн хичээлийн хөгжлийн сан" хэсгийг хөгжүүлэх, контентын сан үүсгэх процессыг баталгаажуулан байршуулахад бэлэн болсон байна. Жилийн эцэст: Мэдлэ цахим контентын	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс

					системд "Сайн хичээлийн хөгжлийн сан" хэсгийг хөгжүүлэх, контентын санд шаардлага хангасан хичээлийг байршуулж, Мэдлэ 2.0 вэб хувилбар луу бүрэн шилжсэн байна.		
2.2.	Ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулах	Улсын төсөв	- Сургалтад хамрагдсан суралцагчдын тоо - Сургалт зохион байгуулсан багшийн тоо	2025-2026 хичээлийн жилийн ахлах ангийн 16 хичээл сонголтыг 10 ангийн 44,631, 11 ангийн 45820 хүүхэд, 12 ангийн 42669 суралцагч хичээл сонголт хийсэн. Түүнээс бүлэг бүрдээгүй 449 /нийслэл-107 аймгийн төв-108, сум-221, баг-13/ сургуулийн 10-р ангийн 6740, 11-р ангийн 5384 сурагч, 12-р ангийн 4874 нийт 16998 суралцагч цахим сургуульд суралцаж байна.	Эхний хагас жилд: 2025-2026 оны хичээлийн жилд 10, 11, 12-р ангийн сонгон судлах хөтөлбөрийг цахимаар хэрэгжүүлсэн байна. 2025-2026 оны хичээлийн жилд сонгон судлах хөтөлбөрт хамрагдах урьдчилсан хичээл сонголтыг ЛМС тэй хамтран зохион байгуулна. Урьдчилсан сонголтын нэгдсэн статистик мэдээлэлд тулгуурлан цахим сургалт зохион байгуулах багшийг бэлтгэнэ. *Цахимаар суралцсан хичээлийн үнэлгээг суралцагчийн сонгон судлах хичээлийн жилийн эцсийн үнэлгээнд автоматаар татагддаг байхаар хөгжүүлсэн байна. Жилийн эцэст: 2026-2027 оны хичээлийн жилд 10, 11, 12-р ангийн сонгон судлах хөтөлбөрийн хичээл сонголт зохион байгуулах, эрх бүхий байгууллагуудыг мэдээллээр хангаж, цахим сургалтын хэвийн үйл ажиллагааг хангасан байна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс, Цахим сургалтын хэлтэс
3.	Боловсролын цахим үйлчилгээг өргөжүүлэх - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого / үе шат (2021-2030), зорилт 2.1.2, 2.1.4, 2.1.5 дахь заалт - Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дугаартай "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" тогтоолын 1-р хавсралт, "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" 2.2.1.13, 2.2.4.1, - "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" 2.2.4.1, 2.2.4.2, 2.2.4.3, 2.2.4.5 дахь заалтууд - Боловсролын ерөнхий хууль 8.2, 12.12, 43.1 заалт						
3.1.	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад	Улсын төсөв	- Сайжруулалт т хийсэн модулийн	Нийслэлийн СӨБ I, II шатны хүсэлт хүлээн авах үйл	Эхний хагас жилд: СӨБ-ийн элсэлтийн цахим системийг шинэчлэн бодлого шийдэл гаргаж хөгжүүлэн туршсан байна.	II улирал IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн

	суралцагчийн элсэлтийн цахим бүртгэлийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх системийг хөгжүүлэх		тоо - Цахимаар ирсэн хүсэлтийн тоо	ажиллагааг 2025 оны 8 сарын 04-өөс 9 сарын 12-ны хооронд e-mongolia.mn болон elself.esis.edu.mn-р зохион байгуулсан. СӨБ-д хамрагдах суралцагчийн хүсэлтийн төлөвийг 1 удаа өөрчлөх боломжтой байгаа. Энэ үйл ажиллагааг уламжлалтын бүртгэл дээр зөрчиж гар ажиллагаагаар төлөвийн мэдээллийг 1-ээс олон удаа өөрчлөх хүсэлтүүд ирүүлж байна.	(НБГ, ДБГ, дэмжлэг баг) СӨБ-ийн уламжлалтын бүртгэл ажлын даалгавар ирүүлсний дараа системд төлөвийн өөрчлөлт хийх болон суралцагчдыг хаана бүртгэлтэй байгааг дэлгэрэнгүй харуулах нэмэлт хөгжүүлэлт хийж төлөвийн мэдээллийг өөрчлөх үйл ажиллагааг интерфэйсжүүлэх судалгаа шинжилгээ, хөгжүүлэлт хийж нэвтрүүлнэ. Жилийн эцэст: Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцагчийн элсэлтийн цахим бүртгэлийг үе шаттайгаар зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, элсэлтийн модулийн сайжруулалтыг хийж, тогтвортой байдлыг хангасан байна.		хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
3.2	Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн элсэлтийн цахим бүртгэлийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх системийг хөгжүүлэх	Улсын төсөв	- Сайжруулалт хийсэн модулийн тоо - Цахимаар ирсэн хүсэлтийн тоо	Төрийн өмчийн ерөнхий боловсролын нэгдүгээр ангийн элсэлтийг цахимаар зохион байгуулсан. 1-р ангид элсэх суралцагчдын нийт жагсаалтыг УБЕГ-аас хүлээн авах процесс хууль эрх зүйн үндэслэл тодорхойгүй байна.	Эхний хагас жилд: ЕБС -ийн элсэлтийн мэдээлэл солилцооны сервис хөгжүүлэн туршсан байна. (ЛМС систем) 1-р ангид элсэх суралцагчдын нийт жагсаалтыг УБЕГ-аас хууль тогтоомжид нийцүүлэн сервис байдлаар авах боломжийг бүрдүүлэн туршсан байна. Жилийн эцэст: Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн элсэлтийн цахим бүртгэлийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх элсэлтийн системийн тогтвортой байдлыг хангасан байна.	III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
3.3	Боловсролын төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэх	Улсын төсөв	- Нэмэгдсэн үйлчилгээний тоо - Сайжруулал	- СӨБ-ын хөнгөлөлт эдлэх суралцагчдын	Эхний хагас жилд: 1. ХХҮЕГ-аас сервис хөгжүүлэн гаргаж хүлээн авсны дараа мэдээлэл солилцогч байгууллагуудад	I улирал,	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн

			т өөрчлөлт хийсэн сервисийн тоо	мэдээллийг ХХҮЕГ-аас нууцын журмаар эксел файлаар мэдээлэл хүлээн авдаг. Мэдээллийг цаг тухайд нь шинэчлэл хийх шаардлага үүссэн. - 2000-2018 онд бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчдийн мэдээллийг системд бүртгэх болон баталгаажуулалт хийх боломжтой систем хөгжүүлж аймаг, орон нутгийн БГ-уудад хэрэглэгчийн эрх хүргүүлж бүртгэл хийлгэн БЕГ-аар баталгаажуулалт хийлгэж байна.	хөнгөлөлт эдлэх суралцагчдын мэдээллийг цаг тухай бүрд нь шинэчлэл хийх боломжтой сервис хөгжүүлэн, мэдээлэл солилцоно. 2. 2000-2018 онд бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчдийн мэдээллийг e-mongolia-д харуулах нэмэлт сервис хөгжүүлэх, лавлагаа харуулах хүсэлт гаргаж төгсөгчид e-mongolia-аас лавлагаа авах боломжтой болно. Дэлгэрэнгүйг хавсралтад тусгав Жилийн эцэст: Зорилтод тусгасан боловсролын төрийн цахим үйлчилгээний тогтвортой ажиллагааг ханган ажилласан байна.	II улирал, III улирал, IV улирал	хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
3.4	Боловсролын салбарын мэдээллийн системтэй мэдээлэл солилцох байгууллагын гэрээний бүртгэл	Улсын төсөв	- Сайжруулалт хийсэн ажлын тоо	Боловсролын сайдын 2024 оны 12 сарын 19 өдрийн А/260 тоот тушаалаар "Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журам" шинэчлэн баталсантай холбоотой цахим системтэй байх	Эхний хагас жилд: Мэдээлэл солилцох гэрээ байгуулсан байгууллагын бүртгэлийн системд дээд боловсролын системийн төрлийг нэмэх, дээд боловсролын сургалтын байгууллагын гэрээ бүртгэх боломжтой хөгжүүлэлт хийгдсэн байна. Жилийн эцэст: Системийн төлөвлөлтийн дагуу нэмэлт сайжруулалт засвар хийж, тогтвортой ажиллагааг хангана.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс

				шаардлагатай. Суурь нөхцөл бүртгэлийн модуль байхгүй.			
4.	<p>Боловсролын салбарын мэдээллийн системийн хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, тогтвортой ажиллагааг хангах</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хэвсрэлт "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого / үе шат (2021-2030) зорилт 2.1.2, 2.1.4, 2.1.5 дахь заалтууд - Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дугаартай "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" тогтоолын 1-р хэвсрэлт "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" 2.2.1.13, 2.2.4.1 - "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" 2.2.4.1, 2.2.4.3 дахь заалт, - Боловсролын ерөнхий хууль 8.2, 12.12, 43.1 заалт 						
4.1.	Сургуулийн өмнөх боловсролын салбарын удирдлагын мэдээллийн системийн модулийн сайжруулалт, статистик тайлан нэгтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, тогтвортой ажиллагаа хангах	Улсын төсөв	-Сайжруулалт хийсэн тайлангийн тоо	Сургуулийн өмнөх боловсролын салбарын мэдээллийн системийг төрийн болон хувийн өмчийн бүх сургалтын байгууллагууд 2024-2025 оны хичээлийн жилд 3 тайлант үеийн анхан шатны 11, захиргааны 14, албан ёсны 4 нийт 29 маягтын дагуу системийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан.	Эхний хагас жилд: Системийн тогтвортой ажиллагааг хангаж тайлан мэдээг хугацаанд нэгтгэж илгээсэн байна. Жилийн эцэст: Системийн тогтвортой ажиллагааг хангаж тайлан мэдээг хугацаанд нэгтгэж илгээсэн байна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
4.2.	Ерөнхий боловсролын салбарын удирдлагын мэдээллийн системийн модулийн сайжруулалт,	Улсын төсөв	Нэгтгэсэн тайлангийн тоо Сайжруулалт хийсэн тайлангийн тоо	Ерөнхий боловсролын салбарын мэдээллийн системийг төрийн болон хувийн өмчийн бүх	Эхний хагас жилд: Системийн тогтвортой ажиллагааг хангаж тайлан мэдээг хугацаанд нь нэгтгэж илгээсэн байна. Намрын статистик тайлангийн хүрээнд бодлого шийдэл, процессыг тодорхойлсон байна. Жилийн эцэст: Намрын статистик	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс

	статистик тайлан нэгтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, тогтвортой ажиллагаа хангах			сургалтын байгууллагууд 2024-2025 оны хичээлийн жилд 6 тайлант үеийн нийт 111 маягтын дагуу системийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан.	тайлангийн хүрээнд Боловсролын яамнаас ирүүлсэн маягтын өөрчлөлтийг тусгаж, мэдээлэл солилцох байгууллагад шаардлагатай сервисийг хөгжүүлэн нэвтрүүлсэн байна.		
4.3.	Мэргэжлийн боловсролын салбарын удирдлагын мэдээллийн системийн модулийн сайжруулалт, статистик тайлан нэгтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, тогтвортой ажиллагаа хангах	Улсын төсөв	-Шинээр хийсэн тайлангийн тоо	Техник болон мэргэжлийн боловсролын салбарын мэдээллийн системийг шинээр нэвтрүүлэхээр зорьж байна.	Эхний хагас жилд: Батлагдсан статистик тайлангийн бодлого шийдлийг боловсруулж баталгаажуулан төсөв хөрөнгө, хаврын тайланг хөгжүүлж нэвтрүүлсэн байна. Жилийн эцэст: Батлагдсан бодлогын баримт бичгийн дагуу шинээр хөгжүүлэлт хийж, хугацаанд нь нэвтрүүлэн тогтвортой ажиллагааг хангасан байна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
4.4.	Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системийн модулийн сайжруулалт, статистик тайлан нэгтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, тогтвортой ажиллагаа хангах	Улсын төсөв	Нэгтгэсэн тайлангийн тоо	Дээд боловсролын удирдлага мэдээллийн системийг төрийн болон хувийн өмчийн бүх сургалтын байгууллагууд ашиглаж байна.	Эхний хагас жилд: Системийн тогтвортой ажиллагааг хангаж тайлан мэдээг хугацаанд нэгтгэж илгээсэн байна. Жилийн эцэст: Системийн тогтвортой ажиллагааг хангаж тайлан мэдээг хугацаанд нэгтгэж илгээсэн байна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
4.5.	Сургуулийн өмнөх боловсролын хичээлийн жилийн хаалтын дэвшилт,	Улсын төсөв	- Дэвшилт төгсөлт хийсэн байгууллагын тоо - Дэвшилт	Сургуулийн өмнөх боловсролын салбарын мэдээллийн	Эхний хагас жилд: Системийн тогтвортой ажиллагааг хангаж тайлан мэдээг хугацаанд нэгтгэсэн байна. Жилийн эцэст: Системийн тогтвортой	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс,

	төгсөлтийн бүртгэлийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, шаардлагатай сайжруулалтыг системд тусган хөгжүүлэлт хийж, нэвтрүүлэх		төгсөлт хийсэн суралцагчийн тоо	системд суралцагчийн шилжилт хөдөлгөөн, дэвшилтийн бүртгэл, төгсөлтийн бүртгэл, хичээлийн жилийн хаалтын үйл ажиллагааг цахим хэлбэрээр бүртгэж баталгаажуулдаг.	ажиллагааг хангаж тайлан мэдээг хугацаанд нэгтгэсэн байна.		Систем хөгжүүлэлтийн хэлтэс
4.6.	Ерөнхий боловсролын хичээлийн жилийн хаалтын дэвшилт, төгсөлтийн бүртгэлийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, шаардлагатай сайжруулалтыг системд тусган хөгжүүлэлт хийж, нэвтрүүлэх	Улсын төсөв	- Дэвшилт төгсөлт хийсэн байгууллагын тоо - Дэвшилт төгсөлт хийсэн суралцагчийн тоо	Ерөнхий боловсролын салбарын мэдээллийн системд жилийн эцсийн дүн, дэвших шалгалтын дүн, улсын шалгалтын дүн, судлагдахууны дүн /9, 12-р анги/, үнэт цаас хуваарилалт, үнэмлэх, гэрчилгээ хэвлэлт, дэвшилтийн бүртгэл, төгсөлтийн бүртгэл, хичээлийн жилийн хаалтын үйл ажиллагааг цахим хэлбэрээр бүртгэж баталгаажуулдаг.	Эхний хагас жилд: Системийн тогтвортой ажиллагааг хангаж тайлан мэдээг хугацаанд нэгтгэсэн байна. Жилийн эцэст: Системийн тогтвортой ажиллагааг хангаж тайлан мэдээг хугацаанд нэгтгэсэн байна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
4.7.	Мэргэжлийн болон техникийн боловсролын элсэлт, төгсөлт, баримт бичиг олголт, тэтгэлэг олголтын	Улсын төсөв	- Дэвшилт төгсөлт хийсэн байгууллагын тоо - Дэвшилт төгсөлт хийсэн суралцагчийн тоо	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хүлээн авсан мэргэжлийн болон техникийн боловсролын	Эхний хагас жилд: Системийн тогтвортой ажиллагааг хангаж тайлан мэдээг хугацаанд нэгтгэсэн байна. Жилийн эцэст: Системийн тогтвортой ажиллагааг хангаж тайлан мэдээг хугацаанд нэгтгэсэн байна.	II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем

	суурь бүртгэлийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, шаардлагатай сайжруулалтыг системд тусган хөгжүүлэлт хийж, нэвтрүүлэх			mergejl.mn -ийг tvets.edu.mn хаяг дээр тогтвортой байдлыг ханган ажиллуулж байна.			хөгжүүлэлтийн хэлтэс
4.8.	Дээд боловсролын элсэлт, төгсөлт, баримт бичгийн дугаар хуваарилалтын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, шаардлагатай сайжруулалтыг системд тусган хөгжүүлэлт хийж, нэвтрүүлэх	Улсын төсөв	Дэвшилт төгсөлт хийсэн байгууллагын тоо Дэвшилт төгсөлт хийсэн суралцагчийн тоо	Дээд боловсролын удирдлага мэдээллийн системийг ашиглан элсэлт, төгсөлт, баримт бичгийн дугаар хуваарилалтын үйл ажиллагааны бүртгэлийг төрийн болон хувийн өмчийн бүх сургалтын байгууллагууд хөтлөн явуулж байна.	Эхний хагас жилд: Системийн тогтвортой ажиллагааг хангаж тайлан мэдээг хугацаанд нэгтгэсэн байна. Жилийн эцэст: Системийн тогтвортой ажиллагааг хангаж тайлан мэдээг хугацаанд нэгтгэсэн байна.	I улирал II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
4.9	Сургуульд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ, эрт илрүүлэг зохион байгуулах системийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн салбар дундын цахим мэдээллийн сантай болгох	Улсын төсөв	Мэдээлэл солилцсон сервисийн тоо	Судалгааны түвшинд 15% гүйцэтгэлтэй байгаа	Эхний хагас жилд: Системийн процесс хэрэгцээ шаардлагын дагуу шаардлагатай мэдээлэл солилцооны сервисийг хөгжүүлэн хамтран ажилласан байна. Жилийн эцэст: Системийн процесс хэрэгцээ шаардлагын дагуу шаардлагатай мэдээлэл солилцооны сервисийг хөгжүүлэн хамтран ажилласан байна.	I улирал II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс

4.10	Боловсролын бодлого, санхүүжилт, хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд их өгөгдөлд суурилсан дата аналитикийн дашбоард хөгжүүлж, нэвтрүүлэх	Улсын төсөв	Мэдээлэл солилцсон сервисийн тоо	Одоогоор систем байхгүй	Эхний хагас жилд: Системийн процесс хэрэгцээ шаардлагын дагуу шаардлагатай мэдээлэл солилцооны сервисийг хөгжүүлэн хамтран ажилласан байна. Жилийн эцэст: Системийн процесс хэрэгцээ шаардлагын дагуу шаардлагатай мэдээлэл солилцооны сервисийг хөгжүүлэн хамтран ажилласан байна.	I улирал II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
4.11	Багш ажлын байрандаа тасралтгүй хөгжихөд дэмжих, ачааллыг бууруулах зорилгоор хиймэл оюун ухаанд суурилсан багшийн виртуал туслахыг туршилтын байдлаар нэвтрүүлэх	Улсын төсөв	Мэдээлэл солилцсон сервисийн тоо	Одоогоор систем байхгүй	Эхний хагас жилд: Системийн процесс хэрэгцээ шаардлагын дагуу шаардлагатай мэдээлэл солилцооны сервисийг хөгжүүлэн хамтран ажилласан байна. Жилийн эцэст: Системийн процесс хэрэгцээ шаардлагын дагуу шаардлагатай мэдээлэл солилцооны сервисийг хөгжүүлэн хамтран ажилласан байна.	I улирал II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
4.12	Боловсролын сургалтын байгууллагад нэгдсэн стандарт, архитектур бүхий удирдлага, мэдээллийн системийг нэвтрүүлж, мэдээлэл солилцоог сайжруулах	Улсын төсөв	Мэдээлэл солилцсон сервисийн тоо	Одоогийн ESIS систем хуучирсан шинэчлэх шаардлагатай байгаа	Эхний хагас жилд: Системийн процесс хэрэгцээ шаардлагын дагуу шаардлагатай мэдээлэл солилцооны сервисийг хөгжүүлэн хамтран ажилласан байна. Жилийн эцэст: Системийн процесс хэрэгцээ шаардлагын дагуу шаардлагатай мэдээлэл солилцооны сервисийг хөгжүүлэн хамтран ажилласан байна.	I улирал II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем хөгжүүлэлтийн хэлтэс
4.13	Иргэдийн насан туршдаа суралцахуйн удирдлага мэдээллийн	Улсын төсөв	Мэдээлэл солилцсон сервисийн тоо	Одоогоор систем байхгүй	Эхний хагас жилд: Системийн процесс хэрэгцээ шаардлагын дагуу шаардлагатай мэдээлэл солилцооны сервисийг хөгжүүлэн хамтран ажилласан байна. Жилийн эцэст: Системийн процесс хэрэгцээ шаардлагын дагуу	I улирал II улирал, III улирал, IV улирал	Системийн шинжилгээ, төлөвлөлтийн хэлтэс, Систем

	системийг хөгжүүлж, нэвтрүүлэх				шаардлагатай мэдээлэл солилцооны сервисийг хөгжүүлэн хамтран ажилласан байна.		хөгжүүлэлтийн хэлтэс
5.	Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлага						
	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого I үе шат (2021-2030) зорилт 1.3.2 - "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" 2.2.4.1, 2.2.4.3 дахь заалт, - Боловсролын ерөнхий хууль 8.2, 12.12, 43.1 заалт, холбогдох бусад хуулийн заалтууд 						
5.1	Салбарын бодлого, төлөвлөлттэй холбоотой болон шинээр батлагдсан хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг ханган ажиллах	Улсын төсөв	Шинээр батлагдсан салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журмын тоо	Хууль дүрмийн заалтаар хүлээсэн үүргийн дагуу ажиллаж байна.	Эхний хагас жилд: Шинээр батлагдсан салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журмын мэдээллийн сан үүсгэн, албан хэрэгцээнд ашигласан байна Жилийн эцэст: Батлагдсан хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Захиргаа, удирдлагын хэлтэс
5.2	Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй, тогтвортой байдлыг хангаж, хөдөлмөрийн дотоод журмыг мөрдүүлэн ажиллана.	Улсын төсөв	Төвийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах шаардлагатай ажил үйлчилгээг хэрэгжүүлсэн байх	Дотоод журамд заасан зүйл заалтууд, хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг байгууллага дотооддоо шийдсэн байдал	Эхний хагас жилд: Байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангагдаж, хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажилладаг соёл төлөвшинэ. Жилийн эцэст: Хөдөлмөрийн хууль, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг дүгнэсэн байна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Захиргаа, удирдлагын хэлтэс
5.3	Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна.	Улсын төсөв	Худалдан авах ажлын төлөвлөгөө батлагдсан, үнэлгээний хороо байгуулж тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.	Төлөвлөгөөнд тусгагдсан ажил үйлчилгээг цаг тухайд нь чанартай зохион байгуулан ажиллаж байна.	Эхний хагас жилд: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, үнэлгээний хороо байгуулах тушаал батлагдаж, тендер шалгаруулалтуудыг зохион байгуулсан байна. Жилийн эцэст: Худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэсэн байна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Захиргаа, удирдлагын хэлтэс

5.4	Байгууллагын төсөв санхүүгийн үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулах, и-гэрээ нэвтрүүлэх	Улсын төсөв	Төсвийг зориулалтын дагуу зарцуулах, өр авлага үүсгэхгүй төсөв, гүйцэтгэлийг ил тод, хугацаанд нь тайлагнах	Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Шилэн дансны хуулийн дагуу зохион байгуулан ажиллаж байна.	Эхний хагас жилд: Байгууллагын санхүүгийн ил тод байдлыг хангаж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлнэ. Жилийн эцэст: Байгууллагын санхүүгийн ил тод байдлыг хангаж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлнэ.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Захиргаа, удирдлагын хэлтэс
5.5	Хүний нөөцийн сонгон шалгаруулалт, ажилтныг дадлагажуулах, хөгжлийг дэмжих ажлыг зохион байгуулах, хүний нөөцийг бүрдүүлэх	Улсын төсөв	Холбогдох хууль тогтоомжийн дагуу хүний нөөцийн үйл ажиллагааг зохион байгуулсан байх.	Хөдөлмөрийн хууль, Боловсролын сайдын тушаал шийдвэрт нийцүүлэн бүтэц, зохион байгуулалтыг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	Эхний хагас жилд: Шаардлагатай ажлын байранд сонгон шалгаруулалт хийхдээ хэмнэлтийн болон чадахуйн зарчмыг хослуулан баримталж, сонгон шалгаруулалтын процесс ил тод, ойлгомжтой болж, шинэ ажилтны дасан зохицох хугацаа богиносно. Жилийн эцэст: Хүний нөөцийн сонгон шалгаруулалт, ажилтныг дадлагажуулах, хөгжлийг дэмжих ажлыг үе шаттай зохион байгуулна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Захиргаа, удирдлагын хэлтэс
5.6	Ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтныг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;	Улсын төсөв	Ажлын байрны эрүүл, аюулгүй байдлын стандарт зөрчигдөөгүй, үйлдвэрлэлийн осол гараагүй байх.	Шинэ ажилтны, төлөвлөгөөт болон цаг үеийн шинжтэй зааварчилгааг хүргэж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	Эхний хагас жилд: ХАБ-ын зөвлөмжийг тогтмолжуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллээр ханган, ая тухтай ажиллах орчныг бүрдүүлнэ. Жилийн эцэст: ХАБ-ын зөвлөмжийг тогтмолжуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллээр ханган, ая тухтай ажиллах орчныг бүрдүүлнэ.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Захиргаа, удирдлагын хэлтэс
5.7	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллах	Улсын төсөв	Баримт бичиг гүйцэтгэл, шийдвэрлэлтийн хувь	Архив, албан хэрэг хөтлөлийн хууль, дүрэм мөрдөн ажиллаж байна.	Эхний хагас жилд: Байгууллагын архивын баримт бичгийг стандартын дагуу бүрдүүлсэн байна. Жилийн эцэст: Байгууллагын архивын баримт бичгийг стандартын дагуу бүрдүүлсэн байна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Захиргаа, удирдлагын хэлтэс

5.8	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах	Улсын төсөв	Цахим үйлчилгээнд мониторинг хийсэн байдал	Одоогоор нэвтрүүлсэн байгаа цахим үйлчилгээ	Эхний хагас жилд: Хяналт, үнэлгээ хийж, сайжруулах саналын дагуу үйл ажиллагаанд ахиц гаргасан байна. Жилийн эцэст: иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр санаачилга гарган ажилласан байна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Захиргаа, удирдлагын хэлтэс
5.9	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	Улсын төсөв	Гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байх.	Тухайн жилд байгуулсан гэрээний тоо	Эхний хагас жилд: Гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж хэрэгжилтийг хангасан байна. Жилийн эцэст: Гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байдал, хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулсан байна.	I улирал, II улирал, III улирал, IV улирал	Захиргаа, удирдлагын хэлтэс
5.10	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан чиг үүргийн хүрээнд 1-110 дугаарыг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх, сурталчлах, байгууллагын цахим хуудас болон бусад сүлжээгээр олон	Улсын төсөв	Тусгай дугаарыг байгууллагын цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байдлаар байршуулсан байх.	Өмнөх тусгай дугаар болох 110 тусгай дугаарыг байршуулж сурталчилж байна	Эхний хагас жилд: 1-110 дугаарыг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх, сурталчлах, байгууллагын цахим хуудас болон бусад сүлжээгээр олон нийтэд тогтмол сурталчилсан байх. Жилийн эцэст: 1-110 дугаарыг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх, сурталчлах, байгууллагын цахим хуудас болон бусад сүлжээгээр олон нийтэд тогтмол сурталчилсан байх.	II улирал, IV улирал	Захиргаа, удирдлагын хэлтэс

	нийтэд тогтмол сурталчлах						
5.11	Олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд тэднийг татан оролцуулах 3-аас доошгүй арга хэмжээг зохион байгуулах;	Улсын төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Авлигын эсрэг хуульд заасан нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа арга хэмжээ зохион байгуулагдаагүй байна.	Эхний хагас жилд: Зорилтот гурваас доошгүй арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тайлагнасан байх Жилийн эцэст: Зорилтот гурваас доошгүй арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тайлагнасан байх	II улирал, IV улирал	Захиргаа, удирдлагын хэлтэс
5.12	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг нээлттэй байршуулж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Улсын төсөв	Хуулийн хугацаанд байршуулсан нээлттэй мэдээллийн тоо	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг нээлттэй байршуулж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	Эхний хагас жилд: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг нээлттэй байршуулж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Жилийн эцэст: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг нээлттэй байршуулж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	II улирал, IV улирал	Захиргаа, удирдлагын хэлтэс
5.13	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Улсын төсөв	Хуулийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, Ёс зүйн шалтгаантай гомдол маргааныг шийдвэрлэсэн тоон мэдээлэл	Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	Эхний хагас жилд: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна. Жилийн эцэст: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	II улирал, IV улирал	Захиргаа, удирдлагын хэлтэс

—oOo—